

**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН 2023 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ ТАЙЛАН**

2024 оны 01 дүгээр сарын 09-ны өдөр

Үндсэн үйл ажиллагааны талаар

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь Хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, хөгжлийн бодлогын баримт бичигт салбарын сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, үр дүнд үнэлгээ өгөх, дүгнэлт зөвлөмж гаргах, тайлагнах, Байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үр дүнд нь үнэлгээ өгөх, дүгнэлт, зөвлөмж гаргах, тайлагнах, харьяа байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийж, дүгнэлт зөвлөмж гарган тайлагнах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, дүгнэлт зөвлөмж боловсруулах, үр дүнг тайлагнах ажлыг зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө үзүүлэх чиг үүргийн хүрээнд ажиллалаа.

Тус газар нь Монгол улсын Засгийн газрын 2020 оны Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийг батлах тухай 105 дугаар тогтоол, УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны А/103-р тушаалаар 8 албан хаагчийн бүтэц орон тоотойгоор батлагдан ХШҮДАГ-ын даргаар Т.Баасанпүрэв, ахлах шинжээч И.Баттуяа, ахлах мэргэжилтэн Ж.Энхсайхан, мэргэжилтэн Б.Эрдэнэцэцэг, мэргэжилтэн Л.Мөнхгэрэл, Цахим бодлого, мэдээллийн технологийн хэлтсийн шинжээч Д.Батнайрамдал, мэргэжилтэн Б.Билгүүн нарын бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Тус газар 2023 онд дараах ажлуудыг гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн “Дотоод аудитын төлөвлөгөө батлах тухай” А/31 дүгээр тушаалын дагуу 2023 онд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын хамтарсан-3, гүйцэтгэлийн аудит-3, нийт 6 дотоод аудитыг хийж гүйцэтгэсэн байна.
- “Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тус газрын хэрэгжүүлэх 3 зорилтын 43 арга хэмжээг холбогдох хууль, стандарт, дүрэм, журмын хүрээнд батлагдсан төсөвт багтаан зохион байгуулаж ажилласан бөгөөд гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт жилийн эцсийн байдлаар 93.0 хувиар дүгнэгдсэн.

Салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт, илэрсэн асуудлууд

Тус газар нь харьяа агентлаг, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн төсөв санхүүгийн холбогдолтой хууль тогтоомж, дүрэм журам, стандарт, гэрээг мөрдөж байгаа байдал, хөрөнгийн үр ашигтай зүй зохистой зарцуулалт, санхүүгийн мэдээллийн үнэн зөв найдвартай байдал, хөрөнгийн хадгалалт хамгаалалт, бүртгэл, ашиглалт, зарцуулалт, өмчлөл, эрсдэлийн удирдлагын тогтолцоо үр

ашигтай байдалд санхүү төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас баталсан арга зүйн хүрээнд дотоод аудит хийж хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажилласан.

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/05 дугаар тушаалаар баталсан удирдамжийн дагуу “Эрчис ойл” ТӨХХК-ын үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах 12 зөвлөмж бүхий тайланг гүйцэтгэх удирдлага болон яамны удирдлагад танилцуулав.
2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын “Ашигт малтмал газрын тосны газрын үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд **давтан** аудит хийх” удирдамжаар баталсан ажлын хэсэг 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрөөс ажлын 10 хоногт багтааж Ашигт малтмал, газрын тосны газарт аудит хийсэн. Ажлын хэсэг АМГТГ-ын үйл ажиллагаанд 2022 онд хийсэн хяналт, шалгалтын хүрээнд нийт 78 зөвлөмж /Нүүрсний хэлтэстийн 11 зөвлөмж давхардсан/-ийн биелэлтийг хянаж үзэхэд бүрэн хэрэгжсэн 14, хэрэгжилт хангалтгүй 17, хэрэгжээгүй 36 зөвлөмж байна.
3. Батлагдсан төлөвлөгөөний дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын харьяа байгууллагуудад “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтэд аудит хийсэн. 2023 оны 3 улирын байдлаар

№	Байгууллагын нэр	Мэдээлэл оруулсан байдал						Нийт дүн	
		Төсөв/ гүйцэтгэл		ХО, тендер, ху/авалт		Бусад			
		мэдээлэх тоо	мэдээлсэн тоо	мэдээлэх тоо	мэдээлсэн тоо	мэдээлэх тоо	мэдээлсэн тоо	мэдээлэх тоо	мэдээлсэн тоо
1	УУХҮСайдын төсвийн багц	38	38	20	20	46	46	104	104
2	Яамны аппарат	46	46	11	11	57	57	114	114
3	АМГТГ	51	51	20	20	55	55	126	126
4	ҮГА	51	51	20	20	47	46	118	117
5	Эрчис ойл ХХК	42	42	20	20	46	46	108	108
	ДҮН	228	228	91	91	251	250	570	569

Шилэн дансны мэдээллийг цахим хэлбэрээр байршуулсан байдлыг харахад УУХҮСайдын төсвийн багц-1, Яамны аппарат-2, Ашигт малтмал газрын тосны газар -5 Үндэсний геологийн алба-2 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлж, 1 мэдээллийг байршуулаагүй, Эрчис ойл ХХК -11 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагууд мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж хэвшээд байгаа

хэдий ч төрийн өмчийн оролцоотой хувьцаат компани удаа дараа хоцроосоор байна.

4. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын “Ашигт малтмал газрын тосны газрын үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд **давтан** аудит хийх” удирдамжын хүрээнд ажлын хэсэг “Ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хянан шийдвэрлэсэн байдалд дотоод аудит хийсэн. Шалгалтын хүрээнд нийт 9 зөвлөмжийн биелэлтийг хянаж үзэхэд бүрэн хэрэгжсэн 2, хэрэгжилт хангалтгүй 2, хэрэгжээгүй 7 зөвлөмж байна. Тухайлбал: Удаан жилээр хязгаарлалт хийгдэж буй тусгай зөвшөөрлүүдийн судалгааг нарийвчлан гаргаж холбогдох байгууллагуудтай мэдээлэл солилцсоны үндсэн дээр мэдээллийг шинэчлэх, хязгаарлалтыг үргэлжлүүлэх эсвэл чөлөөлөх асуудлыг яаралтай судлан шийдвэрлэх ажил хангалтгүй хэрэгжиж байна.
5. Газрын тосны хайгуул, ашиглалтын талбайн өртөг нөхөгдөх зардлын хяналтад дотоод аудит хийх ажлыг Үндэсний аудитын газраас II, IV улиралд аудит хийгдсэнтэй холбогдуулан дотоод аудитыг 2024 хүртэл хойшлуулсан.
6. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын “Дотоод аудит хийх тухай” удирдамжаар баталсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд 2023 оны 12 дугаар сарын 10-ний өдрөөс яамны УУХҮЯ-ны худалдан авах ажиллагаанд дотоод аудит хийж 6 заалттай бүхий зөвлөмж хүргүүлэв.

Удирдлага зохион байгуулалтын талаар

Газрын нийт албан хаагчид төрийн жинхэнэ албан хаагчийн ёс зүйн дүрэм, дотоод аудиторын ёс зүйн дүрмийг чанд мөрдөн сахилгын зөрчилгүй ажиллаа.

Хөрөнгө орлогын мэдүүлгийг 2023 оны 2 дугаар сарын 10-ны дотор www.meduuleg.iaac.mn сайтад цахимаар мэдүүлж, ТЗУГ-ын мэдүүлгийг бүртгэх, хянах эрх бүхий албан тушаалтан баталгаажуулсан.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны <https://mmhi.gov.mn/> цахим хуудсанд 12 төрлийн үнэлгээний тайланг оруулж олон нийтэд мэдээлсэн.

Байгууллагын 2023 оны баримт бичиг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу байнга болон түр хадгалах хадгаламжийн нэгжээр ялгаж, хуваарийн дагуу хүлээлгэн өгөхөөр бэлтгэсэн.

Тус газарт 2023 онд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас 132 албан бичиг, өргөдөл гомдол ирүүлснийг зохих хугацаанд шийдвэрлэж ажилласан.

Тус газар нь 7 хоног тутам цаг үеийн асуудлаар шуурхай хуралдаж, үүрэг даалгаварын биелэлтийг гарган шийдвэрлэж ажилласан.

Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын харьяа байгууллагад тухай бүр, тухай бүр, сар, улирлаар хяналт тавьж, хугацаа хоцорсон болон мэдээлэл байршуулаагүй зөрчлийг цаг

тухай бүр нь засуулан мэдээ тайланг холбогдох газруудад хүргүүлэн дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Дүгнэлт

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны ХШҮДАГ нь төсвийн хөрөнгө, өр, төлбөр орлого, зарлага, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалт зэрэг төсвийн бүрдүүлэлт түүний зарцуулалт, байгууллагуудын үйл ажиллагаа болон санхүүгийн үйл ажиллагаанд батлагдсан удирдамжийн дагуу хяналт шалгалт хийж, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гарган эрсдэлийн удирдлагаар хангасан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгууллагын үндсэн үйл ажиллагааг хангах зорилгоор 3 зорилтын нийт 43 арга хэмжээний гүйцэтлэгийн үнэлгээ 93.0 хувьтай дүгнэгдсэн байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн “Дотоод аудитын төлөвлөгөө батлах тухай” А/31 дүгээр тушаалын дагуу 2023 онд 6 дотоод аудиты ажлыг хийж гүйцэтгэж, илэрсэн асуудал, зөвлөмжийг яамны удирдлага болон шалгагдсан байгууллагад танилцуулж, төрийн үйлчилгээг ил тод, шуурхай болгох үндсэн үйл ажиллагаа болон байгууллагын зорилго, зорилтод нөлөөлж болохуйц эрсдэлээс урьдлан сэргийлэх арга хэмжээг авч ажиллалаа.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын баталсан удирдамжийн дагуу эрхлэх асуудлын хүрээний байгууллагын санхүү, дотоод үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хүрээнд аудит хийж, дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартыг даган мөрдөн ажиллав.

Албан хаагчид төрийн жинхэнэ албан хаагчийн ёс зүйн дүрэм, дотоод аудиторын ёс зүйн дүрмийг мөрдөж сахилгын зөрчилгүй ажиллаж байна.

Санал

Цаашид хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын ажлыг эрчимжүүлэх аудитын зөвлөмж дүгнэлтийн хэрэгжилтийг хангахад санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас дараах дэмжлэг туслалцаа шаардлагатай байна.

- Дотоод аудиторуудын мэргэжлийн мэдлэг, чадвараа тасралтгүй дээшлүүлэн хөгжүүлэх боломжийг ханган мэргэшүүлэх сургалтыг улсын салбарын дотоод аудиторын тодорхой сэдэвчилсэн сургалтыг цахим болон бусад хэлбэрээр үе шаттай зохион байгуулах.
- Дотоод аудиторын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилгоор гадаадын болон салбарын ижил төстэй байгууллагуудтай туршлага судлуулах арга хэмжээг төлөвлөгөөтэй зохион байгуулах.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР